

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2006 ОНЫ ШҮҮН
ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮНГИЙН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 2006 онд 10072 хүнд холбогдох 6784 эрүүгийн хэрэг хүлээн авч, 712 хүнд холбогдох 388 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, шүүгдэгч, хохирогч эвлэрснээр болон Өршөөл үзүүлэх тухай хуулиар 655 хүнд холбогдох 393 хэргийг, 406 хүнд холбогдох 102 хэргийг цагаатгах тогтоолоор тус тус хэрэгсэхгүй болгож, 7792 хүнд холбогдох 5558 хэргийг таслан шийдвэрлэж, оны эцэст 507 холбогдогчтой 343 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 20.2 хувиар, ял шийтгүүлэгчид 23.3 хувиар буурчээ.

Анхан шатны шүүхээр 2006 онд таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгчдийг өмнөх онтой нь харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Эрүүгийн хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2005 он	2006 он	тоо	хувь	2005 он	2006 он	тоо	хувь
1	Архангай	234	156	-78	-33.3	379	231	-148	-39.1
2	Баян-Өлгий	89	90	1	1.1	133	141	8	6.02
3	Баянхонгор	113	114	1	0.8	185	156	-29	-15.7
4	Булган	172	138	-34	-19.8	270	207	-63	-23.3
5	Говь-Алтай	95	94	-1	-1.05	154	114	-40	-26
6	Говьсүмбэр	68	69	1	1.4	101	83	-18	-17.8
7	Дархан-Уул	440	356	-84	-19.1	675	554	-121	-17.9
8	Дорнод	199	192	-7	-3.52	286	248	-38	-13.3
9	Дорноговь	236	210	-26	-11	357	290	-67	-18.8
10	Дундговь	128	109	-19	-14.8	197	171	-26	-13.2
11	Завхан	143	120	-23	-16.1	199	161	-38	-19.1
12	Орхон	188	168	-20	-10.6	345	244	-101	-29.3
13	Өвөрхангай	260	225	-35	-13.5	347	316	-31	-8.93
14	Өмнөговь	108	93	-15	-13.9	167	143	-24	-14.4
15	Сүхбаатар	92	91	-1	-1.09	130	124	-6	-4.62
16	Сэлэнгэ	497	352	-145	-29.2	660	498	-162	-24.5
17	Төв	207	161	-46	-22.2	293	242	-51	-17.4
18	Увс	228	166	-62	-27.2	367	251	-116	-31.6
19	Ховд	162	201	39	24.07	219	243	24	11
20	Хөвсгөл	264	162	-102	-38.6	372	229	-143	-38.4
21	Хэнтий	257	256	-1	-0.39	338	325	-13	-3.85
22	Нийслэл	2786	2035	-751	-27	3979	2821	-1158	-29.1

байдалтай байна.

Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Хэнтий, Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод, Орхон, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Завхан, Дархан-Уул, Булган, Төв, Нийслэл, Увс, Сэлэнгэ, Архангай, Хөвсгөл аймагт 0.39-38.6 хувиар буурч, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Ховд аймагт 0.8-24.07 хувиар нэмэгджээ.

Ял шийтгүүлэгчид Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай, Дундговь, Дорнод, Өмнөговь, Баянхонгор, Төв, Говьсүмбэр, Дархан-уул, Дорноговь, Завхан, Булган, Сэлэнгэ, Говь-

Алтай, Нийслэл, Орхон, Увс, Хөвсгөл, Архангай аймагт 0.39-39.1 хувиар буурч, Баян-Өлгий, Ховд аймагт 6.2-11.0 хувиар нэмэгджээ.

Шүүхээр таслан шийдвэрлэгдсэн нийт хэргийн 9.4 хувийг онц хүнд, 23.2 хувийг хүнд, 50.0 хувийг хүндэвтэр, 17.4 хувийг нь хөнгөн төрлийн гэмт хэрэг эзэлж байна.

Анхаарал татаж байгаа эрүүгийн хэргийг авч үзвэл:

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчид			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2005 он	2006 он	тоо	хувь	2005 он	2006 он	тоо	хувь
1	Хүнийг санаатай алах	276	251	-25	-9.06	312	284	-28	-8.97
2	Бусдын бие махбодид хүнд гэтэл санаатай учруулах	290	339	49	16.9	311	355	44	14.15
3	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	2905	2276	-629	-21.7	4879	3518	-1361	-27.9
4	Танхайрах	626	518	-108	-17.3	896	753	-143	-16
5	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	116	85	-31	-26.7	251	174	-77	-30.7
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	594	481	-113	-19	617	505	-112	-18.2
7	Албан тушаалын гэмт хэрэг	23	15	-8	-34.8	28	23	-5	-17.9
8	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	62	53	-9	-14.5	102	85	-17	-16.7

байдалтай байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг нь таслан шийдвэрлэсэн нийт хэргийн 72.3 хувь, ял шийтгүүлэгчдийн 73.1 хувийг эзэлж байгаа бол бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нийлбэр нь нийт хэргийн 58.9 хувийг эзэлжээ.

Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг өнгөрсөн оныхоос 16.9 хувиар өсч, бусдыг санаатай алсан гэмт хэрэг 9.06 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 19.0 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 21.7 хувиар, дээрмийн гэмт хэрэг 26.7 хувиар тус тус буурсан байна.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг авч үзвэл:

Д/д	Үзүүлэлт	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2005 он	2006 он	тоо	хувиар
Ял шийтгүүлэгчид. Үүнээс:	Насанд хүрээгүй этгээд	1195	727	-468	-39.1
	Эмэгтэйчүүд	876	660	-216	-24.6
	Гадаадын харьяат	55	54	-1	-1.8
	Урьд ял шийтгүүлсэн	2051	1801	-250	-12.1
	Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн	1873	1403	-470	-25.1
	Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн	2212	1726	-486	-21.9
	Ажил, сургуульгүй хүмүүс	7206	5240	-1966	-27.2

байдалтай байна.

Гэмт хэргийн улмаас нийтдээ 13 тэрбум 603 сая төгрөгийн хохирол учирч, 565 хүний амь нас хохирч, 2048 хүний биед хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учирчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

Д/д	Төрөл	Бүтэн жилд		Нийт ялын дотор эзлэх хувь	
		2005 он	2006 он	2005 он	2006 он
	Нийт ял шийтгүүлэгчид	10153	7792		
1	Хорих ялаар бүгд Үүнээс:	6947	5454	68.4	70.0
	а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	3136	2660		
	б/ Тэнссэн	2915	1930		
	в/ Эрүүгийн хуулийн 62, 63-р зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс:	888	480		
	а/Насанд хүрээгүй этгээд	748	418		
	б/Жирэмсэн эмэгтэй 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	140	62		
	г/ Өршөөл үзүүлсэн	8	384		
2	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн Үүнээс:	3106	2314	30.6	29.7
	а/ Торгох ял	745	609		
	б/ Албадан ажил хийлгэх ял	645	538		
	в/ Баривчлах ял	1716	1167		
3	Онцгой ял /цаазаар авах/	31	24	0.3	0.3
4	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	69	-	0.7	

байдалтай байна.

Ял шийтгүүлэгчдийн 70.0 хувьд хорих, 6.9 хувьд албадан ажил хийлгэх, 15.0 хувьд баривчлах, 0.3 хувьд онцгой ял тус тус оногдуулсны гадна 7.8 хувь буюу 609 хүнийг 2 тэрбум 655 сая төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ. 2660 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлсэн нь нийт ял шийтгүүлэгчдийн 34.1 хувь, хорих ял шийтгүүлэгчдийн 48.8 хувь болж байна.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 206 хүнд хэрэглэж, тэдгээрээс 55.8 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 366 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

Нийт ял шийтгүүлэгчдийн 3827 буюу 49.1 хувьд хорих ялыг биечлэн эдлүүлсэн ба баривчлах ялаар шийтгэжээ. Хорих ялын биечлэн эдлүүлэх болон баривчлах ялын улсын дундаж хувь дээрмийн гэмт хэрэгт 97.0 хувь, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт 92.0 хувь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт 48.0 хувь, танхайрах гэмт хэрэгт 39.0 хувь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт 28.0 хувь байна.

Шүүх хорих ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн 2660 хүний 61.1 хувийг жирийн, 29.2 хувийг чанга, 9.3 хувийг онцгой, 0.4 хувийг гяндангийн дэглэмд ял эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 1818 хэрэг хүлээн авснаас 1766 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 50.7 хувьд нь тогтоолыг хэвээр үлдээж, 24.0 хувьд нь тогтоолд өөрчлөлт оруулж, 25.3 хувь буюу 448 тогтоолыг хүчингүй болгожээ. Оны эцэст 52 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2005 он	2006 он	2005 он	2006 он	зөрүү /+/,/-/
Хянан шийдвэрлэсэн бүгд	1959	1766			
Хэвээр үлдээсэн	1037	895	52.9	50.7	-2.2
Өөрчлөлт оруулсан	421	423	21.5	24.0	2.5
Хүчингүй болгосон	501	448	25.6	25.3	-0.3
Үлдэгдэл	55	52			

Давж заалдах шатны шүүх 871 тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 49.3 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар эрүүгийн 759 хэрэг хүлээн авснаас, 541 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 190 хэргийг хянаж, хариу өгсөн ба оны эцэст 28 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 59.3 хувийг хэвээр үлдээж, 12.8 хувийг өөрчилж, 27.9 хувийг хүчингүй болгожээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2005 он	2006 он	2005 он	2006 он	зөрүү /+/,/-/
Хүлээн авсан хэрэг	878	759			
Хянан шийдвэрлэсэн бүгд	831	731			
Хянаад хүргүүлсэн	213	190			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	618	541			

Үүнээс:	Хэвээр үлдээсэн	336	321	54.4	59.3	4.9
	Өөрчлөлт оруулсан	103	69	16.7	12.8	-3.9
	Хүчингүй болгосон	179	151	28.9	27.9	-1.0
Үлдэгдэл		47	28			

Хяналтын шатны шүүх 220 тогтоол, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 40.7 хувийг эзэлж байна.

Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд иргэний 39455 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, 9095 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж барагдуулжээ. Иргэний бүгд 27469 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 2977 хэргээр буюу 12.15 хувиар өссөн байна. Оны эцэст иргэний 2891 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Хянан шийдвэрлэсэн нийт 27469 хэргийн 10311 буюу 37.5 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74-р зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 17158 буюу 62.5 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцжээ.

Анхан шатны шүүхээр 2006 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг урьд онтой харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2005 он	2006 он	тоо	хувь
1	Архангай	822	672	-150	-18.2
2	Баян-Өлгий	623	617	-6	-0.96
3	Баянхонгор	660	691	31	4.69
4	Булган	515	853	338	65.6
5	Говь-Алтай	402	694	292	72.6
6	Говьсүмбэр	163	178	15	9.2
7	Дархан-Уул	1137	1270	133	11.7
8	Дорнод	982	1337	355	36.15
9	Дорноговь	492	643	151	30.69
10	Дундговь	462	416	-46	-9.96
11	Завхан	801	908	107	13.36
12	Орхон	980	1073	93	9.49
13	Өвөрхангай	1322	1438	116	8.77
14	Өмнөговь	501	548	47	9.38
15	Сэлэнгэ	1926	2475	549	28.5
16	Сүхбаатар	476	536	60	12.61
17	Төв	667	679	12	1.79
18	Увс	634	650	16	2.52
19	Хөвсгөл	1138	1090	-48	-4.22
20	Ховд	546	811	265	48.5
21	Хэнтий	930	893	-37	-3.98
22	Нийслэл	8313	8997	684	8.22
	Дүн	24492	27469	2977	12.15

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг Төв, Увс, Баянхонгор, Нийслэл, Өвөрхангай, Говьсүмбэр, Өмнөговь, Орхон, Дархан-Уул, Сүхбаатар, Завхан, Сэлэнгэ, Дорноговь, Дорнод,

Ховд, Булган, Говь-Алтай аймагт 1.8-72.6 хувиар өсч, Баян-Өлгий, Хэнтий, Хөвсгөл, Дундговь, Архангай аймагт 0.96-18.2 хувиар буурчээ.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Эрх зүйн харилцааны төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү /+/,/-/
	2005 он	2006 он	2005 он	2006 он	
Нийт иргэний хэрэг .	24492	27469			
Иргэний эрх зүйн маргаан	11082	11715	45.2	42.6	-2.6
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	7056	9090	28.8	33.1	4.3
Гэр бүлийн эрх зүйн маргаан	2955	2989	12.1	10.9	-1.2
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	649	711	2.6	2.6	
Бусад эрх зүйн маргаан Үүнээс:	2750	2964	11.3	10.8	-0.5
Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар	33	129			
Дампуурлын хуулиар	6	52			
Компаний тухай хуулиар	15	59			
Нийгмийн даатгалын багц хуулиар	262	239			
Патентийн хуулиар	8	2			
Зохиогчийн эрхийн тухай хуулиар	2	3			
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	16	27			
Төрийн албаны тухай хуулиар	6	3			
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар	8	3			
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар	251	247			
Бусад хуулиар	2143	2200			

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаантай хэрэг 42.6 хувийг, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн маргаантай хэрэг 33.1 хувийг нь, гэр бүлийн эрх зүйн маргаантай хэрэг 10.9 хувийг, хөдөлмөрийн эрх зүйн маргаантай хэрэг 2.6 хувийг нь эзэлж байна.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар иргэний 1417 хэрэг хүлээн авснаас 1364 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 42.0 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж, 27.0 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 31.0 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 53 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2005 он	2006 он	2005 он	2006 он	зөрүү /+/,/-/
Хянан шийдвэрлэсэн бүгд	1299	1364			
Хэвээр үлдээсэн	562	573	43.2	42.0	-1.2

Өөрчлөлт оруулсан	331	368	25.4	27.0	1.6
Хүчингүй болгосон	406	423	31.2	31.0	-0.2
Үлдэгдэл	81	53			

Давж заалдах шатны шүүх 791 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 58.0 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар иргэний 1079 хэрэг хүлээн авч, 251 -г хянан хариу өгч, 781 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, шийдвэр, магадлалын 41.8 хувийг хэвээр үлдээж, 23.4 хувийг өөрчилж, 34.8 хувийг нь хүчингүй болгож, 47 хэргийн үлдэгдэлтэй байв.

Үзүүлэлт		Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
		2005 он	2006 он	2005 он	2006 он	зөрүү +/- /
Хүлээн авсан хэрэг		875	1079			
Хянан шийдвэрлэсэн бүгд		842	1032			
Хянаад хүргүүлсэн		207	251			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн		635	781			
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	271	326	42.6	41.8	-0.8
	Өөрчлөлт оруулсан	183	183	28.8	23.4	-5.4
	Хүчингүй болгосон	181	272	28.5	34.8	6.3
Үлдэгдэл		33	47			

Хяналтын шатны шүүх 455 шийдвэр, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 58.2 хувийг эзэлж байна.

Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Захиргааны хэргийн шүүхүүд 2006 онд 765 нэхэмжлэл, гомдол хүлээн авч, 222 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, 431 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 45 хэргээр буюу 11.7 хувиар өсчээ.

Оны эцэст 112 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 11 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 32 хэргийн шүүх хуралдааныг хойшлуулж, 69 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

2006 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг шүүх тус бүрээр үзүүлбэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд	
		2005 он	2006 он
1	Архангай	9	7
2	Баян-Өлгий	23	25
3	Баянхонгор	6	10
4	Булган	4	5
5	Говь-Алтай	4	3
6	Говьсүмбэр	4	6
7	Дархан-Уул	6	6
8	Дорнод	15	31
9	Дорноговь	6	4
10	Дундговь	1	3
11	Завхан	29	9
12	Орхон	8	13
13	Өвөрхангай	8	6
14	Өмнөговь	7	9
15	Сүхбаатар	10	13
16	Сэлэнгэ	13	13
17	Төв	10	14
18	Увс	9	8
19	Ховд	15	6
20	Хөвсгөл	18	19
21	Хэнтий	14	10
22	Нийслэл	167	211
	Дүн	386	431

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл,

Хэргийн төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь	
	2005 он	2006 он	2005 он	2006 он
Нийт захиргааны хэрэг	386	431		
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулиар	43	15	11.1	3.5
Төрийн албаны тухай хуулиар	52	74	13.5	17.2
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар	7	14	1.8	3.2
Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй	6	18	1.6	4.2

холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар				
Газрын тухай хуулиар	73	89	18.9	20.6
Ашигт малтмалын тухай хуулиар	19	28	4.9	6.5
Татварын ерөнхий хуулиар	25	31	6.5	7.2
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулиар	17	10	4.4	2.3
Бусад хуулиар	144	152	37.3	35.3

байдалтай байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах журмаар 180 хэрэг хүлээн авснаас, 12 хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэн, 159 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, үүнээс 50.9 хувь буюу 81 шийдвэр, захирамжийг хэвээр үлдээж, 13.9 хувь буюу 22 шийдвэрт өөрчлөлт оруулж, 35.2 хувь буюу 56 шийдвэр, захирамжийг хүчингүй болгож, оны эцэст 9 хэргийн үлдэгдэлтэй гарчээ.

Хяналтын журмаар ирүүлсэн 107 захиргааны хэргээс 2 хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэж, 102 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, оны эцэст 3 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн 102 захиргааны хэргийн 53.9 хувь буюу 55 шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 16.7 хувь буюу 17 шийдвэр магадлалыг өөрчилж, 29.4 хувь буюу 30 шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Дөрөв. Бусад асуудлаар

Анхан шатны шүүхүүд захиргааны 15214 материалыг хянан хэлэлцэж 1067 хүнийг 11422 мянган төгрөгөөр торгож, 14087 хүнд баривчлах, 2 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах шийтгэл тус тус ногдуулж, 58 хүнд захиргааны шийтгэл ногдуулахаас татгалзсан байна.

Тайлангийн хугацаанд шүүхүүд хоригдлыг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 1693 материалыг хянан хэлэлцэж, 27 санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 1094 хоригдлыг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 21 хоригдлын хорих ялыг хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 551 хоригдлын ял эдлэх дэглэмийг өөрчилжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 1849 сэжигтнийг баривчлах тухай материалыг хүлээн авч, 1681 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 168 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2383 хүнийг сэжигтнээр, 2827 хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 203 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад улсын тэмдэгтийн хураамжид 1 тэрбум 302.4 сая төгрөг, үүнээс анхан шатны шүүх 1 тэрбум 183.4 сая төгрөг, давж заалдах шатны шүүх 73.2 сая төгрөг, хяналтын шатны шүүх 45.8 сая төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэв. Хяналтын шатны шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 107.1 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхүүд нийт 67827 хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн 6441, иргэний 36564, захиргааны 653 хэрэг, захиргааны зөрчил 15214, хоригдлыг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн

хөнгөн ялаар солих тухай 1693 хүсэлт, 7262 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх тухай асуудал хэлэлцсэн байна.

Анхан шатны шүүхийн нэг шүүгч дундажаар захиргааны 12 хэрэг, эрүү, иргэний хэрэг, маргаан 227-г хянан шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 1766, иргэний 1364, захиргааны 138 бүгд 3268 хэрэг хянан шийдвэрлэжээ. Энэ шатны шүүхийн нэг шүүгч дундажаар 36 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх буюу Улсын Дээд шүүх иргэний 1032, эрүүгийн 731, захиргааны 107, нийтдээ 1870 хэрэг хянан хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Дээд шүүхийн нэг шүүгчид дундажаар эрүүгийн хэрэг 146, иргэний хэрэг 206, захиргааны 17 хэрэг ногдож байна.

Монгол улсын шүүхүүд 6542 өргөдөл, гомдол хүлээн авснаас 6187 буюу 94.6 хувийг шийдвэрлэн зохих хариуг иргэн, хуулийн этгээдэд өгсөн ба одоо 355 өргөдөл, гомдлыг хянаж байна.

2006 онд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн иргэн, захиргааны хэрэг өсч, анхан болон хяналтын шатны шүүхийн шүүгчид ачаалал ихтэй ажилласан байна

ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.ЭРДЭНЭЧУЛУУН

ШҮҮХИЙН СТАТИСТИК,
ТООН МЭДЭЭЛЭЛ
ХАРИУЦСАН АХЛАХ
ЗААВАРЛАГЧ

С.ЭРДЭНЭЧИМЭГ